



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 04 одөр

Дугаар 4/38

Мандалговь

**“Ирээдүйн эзэд-2020” мэргэжил сонголтын
аян зохион байгуулах тухай**

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.1, 20.5.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаарх баримтлах бодлогын 4.4.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх, 9-12 дугаар ангийн сурагчдад эрсдлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ирээдүйн эзэд-2020” мэргэжил сонголтын аяныг 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 08-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Ирээдүйн эзэд-2020” мэргэжил сонголтын аяныг зохион байгуулахад шаардагдах 346900 (Гурван зуун дөчин зургаан мянга есөн зуу) төгрөгийн зардлыг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат), гишүүддэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж тайланг 2020 оны 06 дугаар сарын 31-ний өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д даалгасугай.



ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



№ 481190075

Газарчилсан дараахад

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2000ны 06 дугаар сарын 04 -ны өдрийн
11:38 тоот тушаалын 07 дүгээр хавсралт

“ИРЭЭДҮЙН ЭЗЭД-2020” МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН АЯН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Гишүүд

Х.Төмөрбат

Залуучуудын хөгжлийн төвийн
ажлын албаны нарийн бичиг

Х.Мөнхсаруул

Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа
мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Б.Мөнх-Оргил

Архив, бичиг хэрэг, олон нийт хариуцсан
ажилтан



Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2020 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн
13 тоот тушаалын 09 дүгээр хавсралт



**“ИРЭЭДҮЙН ЭЗЭД”
Мэргэжил сонголтын аяны удирдамж**

Зорилго: Өсвөр наасны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдад эрсдлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Аяны хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагаа:

1. Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэдээллийг өгөх “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын өдөрлөг зохион байгуулна.
2. “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөөг 9-р ангийн сурагчдад зохион байгуулна.
3. “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяны хүрээнд сурагчдаас судалгаа авна

Хамрагдах хүрээ:

- Өлзийт, Өндөршил сумдын ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагчид

Ерөнхий зохион байгуулагч:

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Боловсрол, соёл, урлагийн газар

Хамтран зохион байгуулагч:

- Сумдын ЗДТГ
- Сумдын ЕБС

Хугацаа: 2020 оны 06-р сарын 05-ны өдрөөс 06-р сарын 08-ны өдрийн хооронд зохион байгуулна.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**



Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн
11:00 тоот тушаалын 03 дүгээр хавсралт

**“МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН АЯН” ӨНДӨРШИЛ, ӨЛЗИЙТ
СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	нэгжийн үнэ	Нийт дүн
1	Бензин	л	63	1460	91900
2	Томилолт	Хүн өдөр	3 хүн /2 хоног	12000	72000
3	Байр	2 хоног	3 хүн	14500	87000
4	Баннер	м ²	12 м ²	8000	96000
Нийт					346900

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**